2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15.00 цагт Баянгол дүүрэг, 28-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн "Хурлын танхим"-д боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссоос Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг үндэслэн Техник импорт ХК-ийн 2025 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн №25/266 тоот албан бичгийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон ирүүлсэн Техник импорт ХК-ийн "Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй болон дэлгэрэнгүй судалгаа"-гаар бүртгэлийн ажиллагааг явуулахад 1 446 755 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 466 хувьцаа эзэмшигчээс 492 894 ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр, нийт 1 429 517 хувьцаа эзэмшдэг 9 хувьцаа эзэмшигч бүртгүүлэв.

Тооллогын комиссын бүртгэлийн ажиллагаа 15 цаг 20 минутанд дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн "Хурлын бүртгэлийн ажиллагаагаар тус хуралд 1 429 217 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувьцаа эзэмшигч оролцохоор бүртгүүлсэн нь компанийн 1 446 755 ширхэг энгийн хувьцааны 98,8 хувийг бүрдүүлж Компанийн тухай хуулийн 69.2 дахь заалт, Техник импорт ХК-ийн "Дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.26 дахь заалтыг тус тус хангасан тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай" ирцийн мэдээллийг Хурлын даргад илтгэв.

Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа хурал зохион байгуулах комиссоос хурлын дэгийн талаарх танилцуулга, хэлэлцэх асуудалтай холбогдох материал, саналын хуудсуудыг хувьцаа эзэмшигчдэд тарааж өгөв.

Хурлын дарга Тооллогын комиссын дүнг үндэслэн хурлыг нээх, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг батлах эсэх талаар хувьцаа эзэмшигчдээс санал хураахад хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид санал нэгтэй "зөвшөөрснөөр" хурлын ажиллагаа эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Техник импорт ХК-ийн ТУЗ-ын Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Ж.Баярсайхан, Цалин, урамшууллын хорооны дарга, хараат бус гишүүн Б.Батсайхан, ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий, ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам нар оролцов.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, уг хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дарга, тооллогын комиссыг томилсон талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолыг Хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Д.Ганцэцэг даргалан удирдаж явуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу хурлын хэлэлцэх асуудлыг хурлын дэгд нэр заасан хариуцсан хүмүүс Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Дэгийн дагуу хурлын дарга Д.Ганцэцэг компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар тус тус танилцуулав.

Хурлын үеэр хэлэлцэх асуудалтай холбогдуулан компанийн холбогдох алба, нэгжээс гаргасан 2024 оны үйл ажиллагааны болон борлуулалтын талаарх тайлан, мэдээллийг харуулж байв.

Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлуудыг танилцуулж дууссаны дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдээс хэлэлцсэн асуудлаар асуух, тодруулах зүйл байгаа эсэх талаар асуухад Хувьцаа эзэмшигчид хэлэлцсэн асуудлын талаар тодорхой мэдээллийг авлаа, асуух зүйл алга байна гэв.

Иймд хурлын дэгийн дагуу Хурлын дарга хурлаар хэлэлцсэн асуудлын талаар хурлаас гарах тогтоолын төсөлд саналын хуудсаар санал хураалт явуулья. Тооллогын комисст саналын хуудсаар санал авч дүнг нэгтгэн танилцуулна уу гэв.

Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн: Тооллогын комисст компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% буюу 1 429 517 ширхэг хувьцаа эзэмшигчийн саналын хуудас ирсэн. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар хэлэлцэх асуудалд саналаа өгсөн байна. Нийт тоологдсон саналын хуудас 9 байна. Үүнээс хүчинтэй саналын хуудас 9, хүчингүй саналын хуудас байхгүй байна. ТУЗ-ын гишүүдийг сонгох саналыг кумулятив аргаар дүгнэж гаргасан. Хурлаар хэлэлцсэн бусад асуудлыг нэг бүрчлэн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” хэлбэрээр санал авч саналын хуудсуудын дүнг нэгтгэж гаргасан. Саналын хуудсуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд хуралд оролцогч нийт 9 хувьцаа эзэмшигч хурлаар хэлэлцсэн 8 асуудлыг бүгд 100%-ийн саналаар дэмжиж зөвшөөрсөн учир хурлын саналын хуудсуудыг үндэслэн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах Тооллогын комиссын тогтоолын төслүүдийг батлуулах шийдвэрийг гаргаж байна.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудыг Хувьцаа эзэмшигч та бүхэн зуун хувь зөвшөөрч дэмжсэн тул 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг батлах шийдвэрийг гаргаж байна. Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилтыг хүсье. Хурал өндөрлөснийг мэдэгдэж байна.

Хурал 17 цаг 30 мин дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ын нарийн бичгийн дарга: О.Бүжинлхам

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА: Д.ГАНЦЭЦЭГ